



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№96 /309/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.05.19

Цаг үе, үйл явдал

БХЯ, ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН АЛБА ХААГЧИД МОД ТАРИЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд Батлан хамгаалах салбар манлайлан оролцож байгаа билээ.

Тэгвэл тус хөдөлгөөний хүрээнд өнөөдөр БХЯ, түүний харьяа байгууллагуудын 100 гаруй алба хаагч Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн Мод уржүүлгийн сургалтын төвд 300 ширхэг хайлаас тарилгаа. Үйл ажиллагаанд БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг тэргүүтэй БХЯ, түүний харьяа байгууллагуудын дарга нар, алба хаагчид оролцсон юм.

Ташрамд, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд Батлан хамгаалах салбар 27 сая ширхэг мод тарьж ургуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.



ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАНД ТАТАГДСАН ДАЙЧДАА ЭРГЭЛЭЭ



Багануур дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб
Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Цэргийн штабын 2022 оны цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу Багануур дүүргээс 2021 оны хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан Зэвсэгт хүчний 336 дугаар ангид алба хааж байгаа дайчдыг эргэх ажлыг энэ сарын 15-ны өдөр зохион байгуулж явууллаа.

Хугацаат цэргийн алба хаагчдыг эргэх ажилд дүүргийн Засаг дарга бөгөөд Батлан хамгаалах товчооны дарга С.Даваасүрэн болон дайчилгаа удирдах бүлгийн гишүүд, хорооны Засаг дарга нар, ЗДТГ-ын Цэргийн штабын офицер, ахлагч, ар гэрийн төлөөлөл бүхий 17 хүний бүрэлдэхүүн оролцсон юм.
Хугацаат цэргийн алба хаагчдад ЗДТГ-аас гарын бэлэг, ар гэрийн захиа, илгээмжийг хүлээлгэн өгч, алба хааж байгаа орчин нөхцөлтэй танилцаж, цаашид цэргийн

албаа нэр төртэй хаах талаар ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа З.Майдар үүрэг чиглэл өгч, албанд нь амжилт хүссэн.
Мөн дүүргийн ЗДТГ-т 7 хоногийн номын аян өрнүүлж, Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн номын санд 1 сая төгрөгийн үнэ бүхий уран зохиол, танин мэдэхүйн ном, сэтгүүл хандивлалаа.
Түүнчлэн энэ үеэр дүүргийн Засаг дарга С.Даваасүрэн, ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа З.Майдар болон дайчилгаа удирдах бүлгийн

Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн захирагч хурандаа А.Болдбаатар, захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа н.Гантөр нар хүлээн авч, ангийн үйл ажиллагаа болон Дорноговь аймгийн Зүүнбаян суманд хэрэгжүүлж байгаа "Эко хотхон" төслийн талаар танилцуулсан юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 20	☁️ 2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 41	☁️ 28

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,128.00	3,133.0
EUR 🇪🇺	3,300.0	3,320.0
CNY 🇨🇳	462.50	465.00
RUB 🇷🇺	43.00	44.00
JPY 🇯🇵	24.40	25.00
KRW 🇰🇷	2.42	2.46

ЗУРХАЙ

2022.05.19 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 17

ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:
Өнгө зүс доройтно
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.10-20.27
Барилдлага:
Рашаан
Шүтэн барилдлага:
Нэр өнгө
Суудал: Хий

Энэ өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, эрдэнийг гадагш өгөх, мал худалдан авах, мал түгээх, сахил санваар авах, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Хануур, төөнүүр хийлгэх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагшаа мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
8511 +112	17	8373

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол	Нийт: 524,096,444
Эдгэрсэн	Нийт: 493,892,737
Нас барсан	Нийт: 6,292,624

Сэтгэц мэдрэл донтолтын үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний удирдамж

Анхан ба үндсэн тусламж үйлчилгээнд ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулав

Хувилбар 2.0

Цахим шууданд

ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ХҮРЭЭНД...



төлөвшүүлэх зорилгын хүрээнд эх оронч үзэл гэж юу вэ, энхийг дэмжих ажиллагааны оролцоо, ач холбогдол сэдвээр хуулийн офицер дэслэгч Э.Энхээрца таниулгыг хийж сурагчдад энхийг дэмжих ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын талаарх видео бичлэгийг үзүүлэхийн зэрэгцээ энхийг сахиулагчдын анги байгууллагдаа дурсгасан дурсгалын зүйлсээр үзэсгэлэн дэлгэн, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслүүдийн талаар хичээл сургалтыг зохион байгуулсан юм. Арга хэмжээний төгсгөлд ангиас бэлтгэсэн урлагийн хэсэгчилсэн тоглолтыг үзүүлж сурагчдын дунд нормативын тэмцээн болон хөгжөөнт тэмцээнийг зохион байгууллаа.

Ахмад Э.МӨНХБОЛОРМАА

Зэвсэгт хүчний 314 дүгээр анги

Ерөнхий цэргийн баярын өдөр болон шинэ цагийн мотобуудлагын цэрэг үүсэн байгуулагдсаны түүхт 66 жилийн ойг тохиолдуулан офицер, ахлагч нарын дунд "Саадын зурвас"-ын тэмцээнийг ангийн Ерөнхий цэргийн мэргэжлийн алба хаагч нар зохион байгуулж, мэргэжлээрээ бахархах, мэргэжлээ сурталчилсан арга хэмжээг зохион байгуулан явууллаа.

Хангай дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдад Монгол цэрэг-Дэлхийн цэрэг сургалт сурталчилгааны ажлыг энэ сарын 16-ны өдөр зохион байгуулж явууллаа.

Сурталчилгааны ажлаар сурагчдад цэрэг эх оронч үзэл хүмүүжлийг



Уг "Саадын зурвас"-ын тэмцээнд нийт 20 цэргийн алба хаагч оролцсоноос тэргүүн байрт дэд ахлагч У.Мөнхсүмбэр, дэд байрт дэд ахлагч Б.Мөнх-Эрдэнэ нар шалгарч медаль, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр тус тус шагнуулав.

Мөн Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан Бага-

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫГ ВИТАМИНЖУУЛАВ



Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, "Энхэд мөнх" эмийн сан хамтран "Ерөнхий цэргийн өдөр"-ийг тохиолдуулан Зэвсэгт хүчний 256 дугаар ангид хугацаат цэргийн алба хааж байгаа нийт цэрэг дайчдын дунд "Гранат шидэлт"-ийн тэмцээнийг

зохион байгуулж, энхийн 5 байранд орсон багийн түрүүч, байлдагч нарыг шагнаж урамшууллаа.

Энэ үеэр "Энхэд мөнх" эмийн сан нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд "Чамайг хайрлая-2" витаминжуулалтын аяныг зохион байгуулж байгаа бөгөөд тус ангийн хугацаат цэргийн алба хаагчдад витамин ач холбогдлын

талаар сургалт зохион байгуулахын зэрэгцээ Зэвсэгт хүчний марш тактикийн тэмцээнд амжилттай оролцсон 35 хугацаат цэргийн алба хаагчдад 1 сарын хэрэглээний витаминг бэлэглэж, цэргийн албанд нь амжилт хүслээ.

Дэд хурандаа Ч.ВАНЧИНСҮРЭН

БАЯН-ӨЛГИЙ ЦЭРГИЙН ХҮРЭЭНИЙ АНГИУД ХАМТАРСАН ТОГЛОЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний түүхт 20 жилийн ойг орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх, Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг сахиулах ажиллагааны оролцоо, ач холбогдол, үүрэг гүйцэтгэсэн байдлыг ард иргэд, хүүхэд залуучуудад сурталчлах ажлын хүрээнд Зэвсэгт хүчний 340, 331 дүгээр ангиуд хамтран Баян-Өлгий аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хамруулсан олон талд арга хэмжээг зохион байгууллаа.

Тодруулбал, Баян-Өлгий аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 200 гаруй сурагчидтай уулзалт, яриа таниулга хийхийг зэрэгцээ аймгийн хөгжимт драмын театрт Монгол цэргийн сүр хүч, яруу алдрыг алдаршуулсан хэсэгчилсэн тоглолтыг толилуулав.

Тус арга хэмжээнд энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдыг алдаршуулж, Ерөнхий боловсролын төгсөх ангийн



сурагчдад мэргэжил сонгох, эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх зэрэг олон төрлийн арга хэмжээг зохион байгууллаа.

Тус арга хэмжээг дэмжин Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга Ц.Нацагдорж, Зэвсэгт хүчний 331 дүгээр

ангийн захирагч хурандаа Ц.Буянтогтох, Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга Б.Ууганжаргал нар оролцож, алба хаагчдад болон хүүхэд залууст мэндчилгээ дэвшүүлсэн юм.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН "ДӨЛ"-ИЙН ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг эх оронч байдал, хүмүүжил олгох, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, тэвчээр хатуужил олгож, Зэвсэгт хүчний залгамж халааг бэлтгэх зорилгоор аймгийн Засаг даргын нэрэмжит аварга шалгаруулах цэрэг-спортын

"Дөл" цогцолбор тэмцээнийг хоёр үе шаттай зохион байгуулагдаж өндөрлөө.

Уг тэмцээнд Ерөнхий боловсролын 9 сургуулийн 130 гаруй тамирчид 2 өдрийн турш гардан тулааны үзүүлэх тоглолт, галын бэлтгэл, биеийн тамирын норматив, марш гүйлтийн тэмцээн, асуулт хариулт, эсээ бичлэгийн уралдаан зэрэг 16-н төрлөөр хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж шилдгүүд тодруулсан юм. Үүнд,

тэргүүн байрт Г.Анхтуяа захиралтай "Авьяас" Ерөнхий боловсролын сургуулийн Б.Тэгшбаян захирагчтай тасаг, дэд байрт Д.Мөнхбаатар захиралтай "Сод-Эрдэм" Ерөнхий боловсролын сургуулийн Г.Дамдинсүрэн захирагчтай тасаг, гутгаар байрт О.Бадраа захиралтай "Эрдмийн далай цогцолбор" сургуулийн Э.Тэмүүжин захирагчтай тасаг, тусгайр байрт М.Сономванчиг захиралтай Цагаан-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн Б.Батбаяр захирагчтай тасаг, Ц.Пүрэвжал захиралтай "Ирээдүй 21 дүгээр зуун цогцолбор" сургуулийн М.Хишигдаваа захирагчтай тасгийн хамт олон тус тус алгарлаа. Ийнхүү хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн нийт сурагчдад хандан тэмцээний хаалтын ажиллагаанд оролцсон аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан баяр хүргэж, амжилт хүслээ.

ХОШУУЧ Т.АНХБАЯР

"МОНГОЛ ЦЭРЭГ-ДЭЛХИЙН ЦЭРЭГ" СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

Зэвсэгт хүчний 331 дүгээр анги

Монгол цэрэг НҮБ-ЫН энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд Зэвсэгт хүчний 331 дүгээр анги Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад "Монгол цэрэг-дэлхийн цэрэг" сэдэвт сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.

Сурталчилгааны багийн бүрэлдэхүүнийг ангийн захирагчийн орлогч, захиргааны удирдлагын тасгийн дарга дэд хурандаа С.Бат-Эрдэнэ ахалж, бүрэлдэхүүнд тэргүүн ахлагч О.Энхболд, уулын бэлтгэлийн ахлах офицер ахмад Э.Энхбаатар, төлөвлөлтийн офицер ахмад Ч.Далантай, соёл хүмүүжлийн офицер ахлах

дэслэгч Б.Гэрэлт-Од, уулын хөтөч, сургагч багш ахлах ахлагч Х.Отгонхүү, пулемётчин ахлагч Б.Улсболд, тоотын захирагч ахлагч Э.Төмөр-Очир, жолооч ахлагч Б.Одонгарав болон дэслэгч Б.Мягмаржав захирагчтай ангийн үлээвэр найрал хөгжмийн салааны бүрэлдэхүүн томилогдон ажиллалаа.

Сурагчдад зориулсан хөтөлбөрийн дагуу Монгол Улсын төрийн далбаа, НҮБ-ын тугийг залж, төрийн дууллаа эгшиглүүлэн арга хэмжээг нээж, "Монгол Улсын Зэвсэгт хүчин Нэгдсэн Үндэсний Байгууллагын энхийг дэмжих ажиллагааны оролцоо" сэдэвт танилцуулгыг захирагчийн орлогч, Захиргааны удирдлагын тасгийн дарга дэд хурандаа С.Бат-Эрдэнэ хийж, Монгол Улсын Зэвсэгт

хүчнээс Афганистан, Ирак улсуудад явагдсан олон үндэстний цэргийн ажиллагаа болон НҮБ-ын энхийг сахиулах "UNAMID", "UNMIL", "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн байдал, туршлага, сургамжийн талаар яриа таниулгыг хийлээ. Энэ үеэр ангийн тэргүүн ахлагч О.Энхболд, ахмад Э.Энхбаатар, ахмад Ч.Далантай, ахлагч Х.Отгонхүү нар сурагчидтай асуулт хариулт, ярилцлага өрнүүлж энхийг сахиулах ажиллагааны оролцоог дэлгэрэнгүй сурталчилсан юм.

Сурталчилгааны арга хэмжээний төгсгөлд ахлагч Б.Улсболд өөрийн зохиосон "Цаст уулын цагаан барсууд", "Тиймээ би эх орны хүү байна" шүлгээ сонордуулж, үлээвэр найрал хөгжмийн салааны бүрэлдэхүүн урлагийн тоглолт

үзүүлж, идэвхтэй оролцсон Цэнгэл сумын 1,2,3 дугаар Ерөнхий боловсролын сургууль, Буянт сумын сургуулийн удирдлагуудад дурсамж гардууллаа.

Ахлах дэслэгч Б.ГЭРЭЛТ-ОД

